



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 4/188

Номгон

“Хонгорын шугуй” ХХК-ны 2017-2018 онд хийж гүйцэтгэсэн
Баянхонгор-Өлзийт чиглэлийн зам дагуу 23000 ширхэг
мод тарих, хашаа хамгаалалтыг хийх, усалгааны
асуудлыг бүрэн шийдвэрлэх ажилд хяналт
шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын
тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.3, Төрийн болон орон нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 дахь
заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хонгорын шугуй” ХХК-ны 2017-2018 онд хийж гүйцэтгэсэн Баянхонгор-
Өлзийт чиглэлийн зам дагуу 23000 ширхэг мод тарих, хашаа хамгаалалтыг хийх,
усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлэх ажилд хяналт шалгалт хийж, дүгнэлт
гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: О.Уртнасан-Сум дундын ойн ангийн дарга

Г.Нансалмаа- Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах
мэргэжилтэн

О.Байгалмаа – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Ж.Лхамдулам-Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль
орчны хяналтын улсын байцаагч

С.Бандихүү – Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль
хамгаалагч


Нарийн бичгийн дарга: Б.Намуун- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Хяналт шалгалт хийх ажлыг хуулийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж,
холбогдох дүгнэлтийг гарган цаашид авах арга хэмжээний талаар 2021 оны 08

601210125

дугаар сарын 13-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН